



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5/03.

Чингис хот

Цэргийн цол, мэргэжлийн зэргийн
нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Засгийн газрын 1999 оны “Цэргийн цолны цалингийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 38 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” 213 дугаар тогтоолын 1 “в”, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/17, 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/1643 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер ахмад Энхбаярын Бат-Арсланд албан тушаалын зэрэглэлийн хошууч цолны нэмэгдлийг, Цэргийн мэргэжлийн зэрэг олгох шалгалтад тэнцэж, цэргийн мэргэжлийн зэрэгтэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Цэргийн штабын дарга Н.Хүрэлээ, Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер ахмад Э.Бат-Арслан нарт цэргийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийг тус тус олгосугай

2. Э.Бат-Арсланд цолны нэмэгдлийг 32 хувиар, Н.Хүрэлээ, Э.Бат-Арслан нарт мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 5 хувиар тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Э.Ариунтунгалагт/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР